



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2022 оны 03 дугаар сарын 28

Байгууллагын нэр:

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Нэгжийн нэр:

Авто бааз

Албан тушаалын нэр:

Хог ачигч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

ЧД, 12-р хороо, Дэнжийн 1000 гудамж
169-1, 169-2, 169-3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хүнд

Онцгой нөхцөл:

Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Зам цэвэрлэгээ, ногоон байгууламжаас гарсан болон хуваарьт зам дагуух гэрээтэй аж ахуйн нэгжийн хог хаягдал, цас мөсийг машинд ачиж зайлуулах

Албан тушаалын зорилт:

- 1.Өдөр тутмын ажлын бэлтгэлийг бүрэн хангах
- 2.Хог хаягдал, цас мөсийг ачиж зайлуулах
- 3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах
- 4.Эрхэлсэн ажлын хүрээнд холбогдох дүрэм журмууд, стандартуудыг мөрдөж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, хариуцан гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Ажил эхлэхээс 30 минутын өмнө ирж, хувцсаа сольж өмсөн, машины угааж цэвэрлэн, ажилд гарах бэлтгэлээ хангах	Цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх	Г
	1.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчлага авч, гарын үсэг зурж баталгаажуулах	Аюулгүй ажиллагааны заавар, шаардлагыг биелүүлж ажиллах	Г
	1.3.Өөр машины ачигч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай тохиолдолд Ашиглалтын инженерийн гаргасан хуваариар ажиллах	Үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Зам талбайн цэвэрлэгээнээс болон ногоон байгууламжаас гарсан хог хаягдал, чулуу шороо, цас мөсийг цуглуулж овоолсон	Хог хаягдал, цас мөсийг талбайд хонуулахгүй түргэн	Г

	газраас нь түргэн шуурхай ачиж зайлуулах	шуурхай ачиж зайлуулсан байдал	
	2.2.Хог ачихдаа нийтийн эзэмшлийн гудамж талбайд байрлуулсан хогийн савыг байнга суллаж, ачих, ачсаны дараа хогийн савны хаалгыг бүрэн хааж, түгжих	Хогийн савны ашиглалтыг сайжруулах	Т
	2.3.Шаардлагатай үед элс шороо, бодис давс зэргийг ачих	Ажлын гүйцэтгэлээр	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Авто зам дээр зогсож хог хаягдал ачиж байхдаа зам тээврийн осол аваараас урьдчилан сэргийлэх	Аюулгүй байдлыг өөрийн зүгээс бүрэн хангаж ажиллах	Г
	3.2.Хог хаягдал ачиж байхдаа хурц үзүүртэй зүйлс, зүү тариур зэргээс бэртэж гэмтэх эрсдэлээс сэргийлэх		Г
	3.3.Тэвшнээс зүүгдэх, өндөр ачаатай тэвшин дээр явахгүй байх	Аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлж ажиллах	Г
	3.4.Машин бүрэн зогссон үед буух, суух, хог ачих үед болон машин ухрах үед ард нь хүн, эд зүйл байгаа эсэхэд хяналт тавин, ослоос урьдчилан сэргийлэх		Г
	3.5.Задгай тэвштэй машин дээр хог ачиж байхдаа аль болох найдвартай барьж өргөх, алдахаас болгоомжлох	Аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлж ажиллах	Г
	3.6.Автомат шахагчтай хог тээврийн машины арын механизмын хүрд, мөн сэрээний таталтаас болгоомжлон, дарааллын дагуу зөв ажиллуулах	Машины тэвшний ажиллагааг бүрэн эзэмшиж сурсан байх	Г
	3.7.Машины даацанд тохируулан ачих, хог хаягдлыг ил задгай тархааж хийсгэхгүйгээр ачиж тээвэрлэх, бүтээлгийг тогтмол хэрэглэх	Дүрэм журмыг мөрдөж ажиллах	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрүүд, стандартуудыг мөрдөж ажиллах	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байх	Г
	4.2.Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох	Дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байх	Г
	4.3.Ажлын байрны ерөнхий шаардлагыг хангахын тулд боловсрол, ур чадвараа дээшлүүлж, ажлынхаа бүтээмжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, санаачлагатай ажиллах	Санаачлагатай, хариуцлагатай ажилласан байдал	Г
	4.4.Цаг үеийн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай, бүрэн биелүүлж, үр дүнг тайлагнах	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байдал	Г
	4.5.Байгууллагаас зохион байгуулж байгаа аливаа сургалт, олон нийтийн арга хэмжээ, цэвэрлэгээ үйлчилгээний ажил, мэдээллийн цагт бүрэн хамрагдах	Оролцооны хувиар	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бага болон түүнээс дээш
Мэргэжил	Мэргэжил шаардахгүй
Мэргэшил	
Туршлага	1-ээс дээш жил ажилласан

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах Бичиг үсгийн чадвартай
	Асуудал шийдвэрлэх	-Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэнд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх
	Бусад	-Техникийн зохих мэдлэгтэй, хурдан шаламгай, бүтээлч сэтгэлгээтэй -Кирилл болон монгол бичгийн дүрэм, бичиг, ярианы чадвартай

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Баазын ерөнхий инженер, Ашиглалтын инженер

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Шуурхай удирдлагын цахим төв
- Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга


Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:


..... Х.Цогцэцэг
(Гарын үсэг) (эцэг/эхийн нэр, өөрийн нэр)

Албан тушаал: Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн


..... Б.Нарангэрэл
(Гарын үсэг) (эцэг/эхийн нэр, өөрийн нэр)

2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:


Байгууллагын нэр: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Шийдвэрийн огноо: 2022 оны 03 дугаар сарын 28

Дугаар: А/23

(Тамга/тэмдэг)

ДАРГА


..... Б.МӨНХЦЭЦЭГ
(Гарын үсэг) (эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр